



**№3.31. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛЫН
ТӨВЛӨРСӨН БАЙГУУЛАМЖИЙГ ШАЛГАХ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:/../..

Шаардлага хангасан асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй нийт оноо:

Эрсдэл үүсэх магадлалын хувь:

Эрсдэл үүсэх магадлал

Б. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

No	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Хяналт шалгалтын асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
	Хог хаягдлын тухай хуулийн 22.1, 24.1, 37.1	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй				
1.Барилга байгууламжийн орчны эрүүл ахуйн шаардлага			0	56		
1	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 2.1	Батлагдсан зураг төслийн дагуу баригдсан зориулалтын байртай	0	5		
2	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 2.2	Хот суурингийн зонхилох салхины доод зүгт байрладаг	0	5		
3	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 2.6	1.8 га-аас багагүй эдэлбэр газартай, түүний 60%-иас багагүй талбайд ногоон байгууламжтай	0	3		
4	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 2.6.	Төвлөрсөн байгууламж нь мал амьтан, гадны хүн орохооргүй, 1.8м-ээс багагүй өндөр хашаа хамгаалалттай, /байнгын харуултай/, гадна талдаа хаяг, биоаюулгүйн тэмдэгтэй	0	3		
5	Хог хаягдлын тухай хуулийн 25.3.5	Байгууламжийн орох, гарах хаалга болон дотор, гадна талбай, зам, устгалын үйл ажиллагааг тасралтгүй хянах хяналтын системтэй	0	10		
6	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 2.3	Цэвэр, бохир усны төвлөрсөн болон хэсгийн системд холбогдсон.	0	5		
7	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 3.1.9-3.1.13	Ажилчдын амрах өрөө, хувцас солих өрөө, угаалгын өрөө, усанд орох өрөө, хоолны газартай	0	5		

8	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 2.4	Хог хаягдлыг боловсруулах байгууламж нь захиргааны болон ажилчдын амрах, усанд орох, хооллох хэсгээс тусдаа байрладаг	0	5		
9	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 3.1	Хог хаягдал хүлээж авах, түр хадгалах хэсэг, халдвартгүйжүүлэх хэсэг, халдвартгүйжүүлсэн хогийг түр хадгалах хэсэг, тээврийн хэрэгсэл болон хогийн сатыг угаах халдвартгүйжүүлэх хэсэг, цэвэр хогийн сав хадгалах хэсэг, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хэсгүүдтэй	0	5		
10	Хог хаягдлын тухай хуулийн 24.12	Аюултай хог хаягдал тээвэрлэдэг тээврийн хэрэгслийг цэвэрлэх, ариутгах байгууламжтай	0	10		
2. Ажиллагсад тавигдах шаардлага			0	40		
11	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 4.1	Эрүүл ахуйч, халдвар судлагч, тоног төхөөрөмжийн инженер, автоклавын, шатаах зуухны болон бутлагч машины операторууд, угаагч, жолооч, ачигч /тээврийн хэрэгсэл бүрт, төвлөрсөн байгууламжийн ээлж бүрт тус тус/ -тай	0	15		
12	Хог хаягдлын тухай хуулийн 26.1.3, ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 4.2	Бүх ажиллагсад нь ЭМБХХМ-ийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтанд хамрагдсан /гэрчилгээтэй/	0	5		
13	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 4.3	Ажилтныг ажилд авахдаа болон цаашид эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулдаг	0	5		
14	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 4.3.	В вируст гепатит, татрангийн эсрэг дархлаажуулалтад заавал хамрагдсан	0	5		
15	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын V хавсралтын 4.4	Хувийн хамгаалах хэрэгсэл /нүүрний хамгаалалт, дулаанд тэсвэртэй бээлий, ажлын гутал гэх мэт/-ээр бүрэн хангагдсан, зөв хэрэглэдэг	0	10		
3.Тусгай хог хаягдлыг тээвэрлэлтийн шаардлага			0	45		
16	Хог хаягдлын тухай хуулийн 24.6, ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 3.3	Тусгайлан тоноглогдсон, хөргүүртэй, битүүмжлэгдсэн зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг	0	5		
17	Хог хаягдлын тухай хуулийн 24.11, ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 3.11	Тээврийн хэрэгслийн гадна урд, ард талд галд тэсвэртэй материалаар хийгдсэн анхааруулах тэмдгийг байрлуулсан	0	5		
18	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 3.12, 4.7	Жолооч ажилд гарахын өмнө тээврийн хэрэгслийн шалгах хуудсыг тогтмол бөглөдөг	0	5		

19	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 3.9	Тээврийн хэрэгсэл тус бүр гал унтраах хэрэгсэл, засварын багаж, хэрэгсэл, механик зогсоогч /тормоз/, цахилгаанаас хамааралгүй асдаг 2ш шар гэрлийг тогтмол авч явдаг	0	3		
20	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 3.9.	Машинд шингэн зүйл гоожих, хог хаягдал асгарахад авах арга хэмжээний заавартай	0	5		
21	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 3.9/	Машинд шингэн зүйл гоожих, хог хаягдал асгарахад цэвэрлэх иж бүрдэл /хоосон нийлэг уут, бээлий, амны хаалт, шингээгч алчуур, халдваргүйжүүлэх бодис, хүрз зэрэг/-тэй	0	5		
22	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 3.9-	Машины дотор тал нь цэвэрлэхэд хялбар, булан тохой нь хурц өнцөггүй, мөлгөр	0	3		
23	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 4.8	Аюултай ачаа ачиж буулгах, тээвэрлэхтэй холбогдсон аргачлал, арга зүйн сургалтад жолоочийг тогтмол хамруулдаг	0	3		
24	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 4.2	Жолооч, ачигч нарт аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюултай ачаа тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж гарын үсэг зуруулдаг. /Эдгээр баримт бичиг болон тээвэрлэлтийн гэрээ /ачаа дагалдах бичиг/, замын хуудсыг жолооч заавал биедээ авч явдаг/	0	5		
25	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 4.10	Тээвэрлэлтийн үед, ачиж, буулгах явцад ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдохоос сэргийлж тэдгээрийг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлсэн	0	3		
26	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын III хавсралтын 5 дугаар зүйл	Ослын үед /халдвартай хог хаягдал тээврийн хэрэгслийн дотор болон эргэн тойронд асгарах, түүний нөлөөлөлд өртөх/ авах арга хэмжээг төлөвлөсөн, мэддэг, бэлэн байдлын шаардлага хангасан	0	3		
4. Тусгай хог хаягдлын устгал, халдваргүйтгэлд тавигдах шаардлага			0	105		
27	Хог хаягдлын тухай хуулийн 26.1.6	Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулж байгаа байгууламж нь онцгой байдлын зохицуулагчтай	0	10		
28	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 1.3.1	Халдвартай хог хаягдлыг зааврын дагуу устгадаг	0	10		

29	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 1.3.2	Хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг зааврын дагуу устгадаг	0	10		
30	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 1.3.3	Эмгэг хог хаягдлыг зааврын дагуу устгадаг	0	10		
31	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 1.3.4	Эмийн болон эсэд хортой хог хаягдлыг зааврын дагуу устгадаг	0	10		
32	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 1.3.5	Химийн бодисын хог хаягдлыг аюулгүйгээр хадгалдаг	0	10		
33	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 1.7.1	Автоклавын халдваргүйжүүлэлтийн чанарыг химийн аргаар тогтмол хянаж бүртгэл хөтөлсөн	0	5		
34	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 1.7.1.	Автоклавын халдваргүйжүүлэлтийн чанарыг биологийн хяналтын индикатороор улиралд 1 удаа хянаж бүртгэл хөтөлсөн	0	5		
35	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 1.8	Автоклавын хяналт, засвар үйлчилгээг тогтмол хийж, техник ашиглалтын паспортад тэмдэглэдэг.	0	5		
36	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 2.4, 2.8.5	Зориулалтын шатаах зуухны хэвийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээний хуваарийг өдөр тутам, 7 хоног, сар, жилээр гарган, хяналт тавьж, бүртгэл хөтөлдөг	0	5		
37	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 2.6.9	Аюулгүй ажиллагааны заавар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврыг ил харагдахуйцаар хананд байрлуулсан	0	5		
38	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 2.7.4	Зуухны үнсийг тусгай зориулалтын тагтай саванд цуглуулж хадгалах бөгөөд зориулалтын ландфилд устгадаг	0	5		
39	ЭМС-ын 2017 оны 505-р тушаалын I хавсралтын 2.7.6	Шатаах зуухнаас ялгарч буй утаа, үнсэнд 3 сар тутамд чанарын хяналт хийдэг	0	5		
40	ЭМС-ын 2019 оны A/537 дугаар тушаалын VI хавсралтын 2.9	Улсын бүртгэлд бүртгэгдсэн, тухайн онд хэрэглэх химийн бодисын жагсаалтад орсон химийн бодисыг ариутгал, халдваргүйтгэлд хэрэглэдэг, нөөцтэй	0	5		
41	ЭМС-ын 2019 оны A/537 дугаар тушаалын II хавсралтын 2.13, IV хавсралтын 1.8	Халдваргүйтгэлийн бодисыг зааврын дагуу бэлтгэж, бодисын үйлчлэх хугацааг мөрддөг	0	5		
5. Үйл ажиллагаанд тавигдах бусад шаардлага				25		
42	ЭМС-ын 2019 оны A/537 дугаар тушаалын III хавсралтын 5.1	Тасаг, нэгж ажлын байрны өртөлтийн эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэлт хүчин зүйлийг тогтоосон	0	5		

43	ЭМС-ын 2019 оны A/537 дугаар тушаалын III хавсралтын 5.7, 5.9	Бүх, тасаг нэгжийг ӨДС-ийн анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай хэрэгсэл бүхий цомгоор хангасан	0	5		
44	ЭМС-ын 2019 оны A/537 дугаар тушаалын III хавсралтын 6.3.1, 6.4	Эрсдэлд өртсөн тохиолдлыг “Маягт-2”-ын дагуу бүртгэж, халдвараас сэргийлэх эмчилгээ, шинжилгээг бүрэн хийдэг	0	5		
45	Монгол улсын Засгийн газрын 311 дүгээр тогтоол	Байгууллагын бүхий л үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын нэгжтэй	0	5		
46	Монгол улсын Засгийн газрын 311 дүгээр тогтоол.	Дотоод хяналтыг төлөвлөгөө графикийн дагуу тогтмол хийдэг	0	5		
НИЙТ ОНОО					0	
ҮНЭЛГЭЭ			0	271 эрсдэл тэй	
БАТАЛГААЖУУЛАЛТ						
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>		<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан</i>			
<i>/ овог, нэр/</i>		<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>			
<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>		<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тамга/</i>			

Тайлбар:

